

БАТЛАВ. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

_____ / Р.ЭНХТАЙВАН /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ” ХХК” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



_____ / Г.ОДСҮРЭН /

**“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ” ХХК-НИЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ХАЯГДАЛ ТҮҮХИЙ
ЭД БОЛОВСРУУЛАН ШАТАХУУН ҮЙЛДВЭРЛЭХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар 6987427/

Хянасан: ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

_____ / П.ШИНЭЦЭЦЭГ /

Боловсруулсан: ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

_____ / Э.ИДЭР /

УЛААНБААТАР ХОТ

2024 ОН

БОМТ АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга	1
1.1 Төслийн байршил:	2
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	15
2.1 Байгаль орчны төлөв байдлын мэдээлэл:	15
2.2.1 Уур амьсгал	15
2.2.1.1 Дулаан, хүйтний горим	15
2.2.1.2 Жилийн улирлын хугацаа	15
2.2.3 Агаарын температур	17
2.2.4 Хур тунадас, чийгшил	17
2.2.5 Цасан бүрхүүл.....	18
2.2.6 Агаарын даралт, салхины горим.....	18
2.3 Агаарын чанар.....	19
2.4 Геоморфологи	19
3.1 Шууд нөлөөлөл	20
3.2 Шууд бус нөлөөлөл	20
3.3 Болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа	21
3.4 Нөлөөллийн буцах болон эргэлт буцалтгүй байдал	21
3.5 Нөлөөллийн эрчимшил.....	21
3.6 Төслийн байршил, шийдэл, төлөвлөлтөөс үүсэх нөлөөлөл.....	22
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	22
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	23
5. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө	23
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	26
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	28
10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29
“Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөө”-ний нэгдсэн дүн	30
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ, НОМЗҮЙН ЖАГСААЛТ:.....	31

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Төслийн товч танилцуулга

Уг төсөл нь “Об ойл индастриал” ХХК-ийн хөрөнгө, дэд бүтцэд тулгуурлан Монгол улсын зах зээлд онцгой хэрэгцээтэй шингэн шатахууныг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлэх.

- Монгол улсын хот суурин газруудаар ихээр хуримтлагдаж байгаа хаягдал түүхий эд хуванцар, ажилласан хаягдал тос цуглуулан авч шатахуун үйлдвэрлэж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж орчны, бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд зохих үүрэг гүйцэтгэж, тус дэм болох.

- Дэлхийн боловсруулах салбарт хэрэгжигдэж байгаа дэвшилтэт технологи ба арга барилуудыг эх нутагтаа нэвтрүүлэн шинэ үеийн боловсон хүчин бэлтгэх.

Дизель түлш нь цемент, ачааны машины дугуй зэргийн адил нэн хэрэгцээт, хөрөнгө оруулалтын зориулалттай бараа буюу эдийн засгийн ирээдүйг илэрхийлдэг нэгдсэн түрүүлэгч индикаторыг тодорхойлдог барааны нэг юм.

Дизель түлшийг боловсруулах аж үйлдвэр манай улсад хөгжөөгүй, импортыг орлуулж чаддаггүй, худалдан авалтад ам.долларын хэлцэл ноёлодог учраас ханшийн эрсдэлтэй, байнга эрэлт хэрэгцээтэй байдаг бараа юм.

Автын болон хүнсий ашигласан хаягдал тосноос дизель үйлдвэрлэх төслүүд нь монголд аль хэдийнээ хэрэгжиж цөөнгүй жилийг туулсан байна. Харин бид бусад үйлдвэрийн түүхий эдийг олж авах алдаа туршлагаар дамжуулан өөрийн үйлдвэрийг илүү өрсөлдөх чадвартай болгох, бусад үйлдвэрийн хүчин чадал, технологийн сонголтоос суралцаж орчин үеийн үр ашигтай технологи нэвтрүүлэх чиглэлийг сайжруулан сонгож байгаа учраас энэхүү төслийг хэрэгжүүлэхээр шийдсэн юм.

Автын болон хүнсний ашигласан хаягдал тосноос дизель үйлдвэрлэх төслүүд өртгийн хувьд өрсөлдөх чадвартай ч бүгдийнх нь хүчин чадал нийлээд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн эсвэл түүнээс арай жижиг уурхайн жилийн хэрэглээний талыг ч хангах хэмжээнд хүрээгүй байгаа нь энэхүү зах зээлд хэрэгжүүлэх ажил олон байгааг илэрхийлнэ.


1.1 Төслийн байршил:

Төсөл хэрэгжиж буй газар нь Төв аймгийн, Аргалант сум, 2-р баг, Хөшөөт 2500мкв

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төслийн нэр	“Хаягдал түүхий эд боловсруулан шатахуун үйлдвэрлэх”
2	БОНЕҮ-ийн дугаар	2023/ОА-78
3	Төсөл хэрэгжүүлэгч	“Об Ойл Индастриал” ХХК
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, БЗД, Энканто таун, 306-22
	Төслийн хүчин чадал үйлчилгээний төрлүүд:	Тус үйлдвэр нь 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр, жилд 6 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулна. Хоногт үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ -Дизель түлш – 5 тн жилийн үйлдвэрлэлийн хугацаанд 1000 орчим тн шатахуун үйлдвэрэнэ.
5	Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	<ul style="list-style-type: none">• ААН гэрчилгээ• Газрын гэрчилгээ• Кадастрын зураг• Галын дүгнэлт• Боломжит усны нөөцийн дүгнэлт• Тохирлын гэрчилгээ




Төсөл хэрэгжиж буй газрын сансрын зураг



Төсөл хэрэгжиж буй газар

Төсөл хэрэгжиж буй орчны харагдах байдал



Төсөл хэрэгжиж буй орчны харагдах байдал





Зураг 4

2024 онд тарьсан мод бут сөөг







Чанх дээрээс харсан байдал



Зураг 6

Ангилан ялгах хогийн сав



Трансформатор



Галын аюулгүй байдлын самбар



ХАБ зааварчилгааны самбар



Нэрэх танк



Үндсэн нэрэх зуух



Нөөцийн танк



Хөрсний зүсэлт, болон дээжлэлт



2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

2.1 Байгаль орчны төлөв байдлын мэдээлэл:

Байгалийн мужлал, бүс бүслүүр, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд(геологийн тогтоц, агаарын чанар, цаг агаар, уур амьсгал, ус зүй, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг) зэргийн өнөөгийн төлөв байдлыг авч үзнэ.

- **Байгалийн мужлал:** Төсөл хэрэгжих газар нь Хангай Хэнтийн уулархаг их мужид багтана.

- **Байгалийн бүс бүслүүр:** Байгалийн бүс бүслүүрийн ангилалаар ойт хээрийн бүсэд хамаарна.

2.2.1 Уур амьсгал

Төслийн ойр орчмын уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс хахир ширүүн цаг агаарын шинжтэй. Улирлын байдлаар хахир, хахирлаг нөлөөтөй, уур амьсгалын үзүүлэлтүүдийн хоног, жилийн явц нь тэгш хэмтэй.

2.2.1.1 Дулаан, хүйтний горим

Олон жилийн дунджаар тухайн орчмын агаарын жилийн дундаж температур -1.5 хэм, 1 дүгээр сард -2.2 хэм, 7 дугаар сард 16.4 хэм бөгөөд жилийн дундаж агууриг нь 36.4 болно. 1 дүгээр сарын үнэмлэхүй бага температур нь -33.6 хэм, 7 дугаар сарын үнэмлэхүй их температур нь 29.8 хэм бөгөөд үнэмлэхүй температурын агууриг нь 63.4 хэм байна. Хөрсний гадаргуугийн жилийн дундаж температур -0.3 -1.5 хэм, 1 дүгээр сард -22.5 -28.0 хэм, 7 дугаар сард 18.5-21.0 хэм орчим байна.

Хөрсний үнэмлэхүй хамгийн дулаан температур 67.0 хэм, хамгийн бага нь -42 хэм болж үнэмлэхүй хамгийн их, бага температурын агууриг 109 хэм байна.


2.2.1.2 Жилийн улирлын хугацаа

Төв аймгийн уур амьсгалын онцлогоос шалтгаалж жилийн турш дулаан хүйтний ялгаа нилээд их байдаг.

Жилийн 4 улирлын уур амьсгал, цаг агаарын онцлог тод илрэлтэй. Өвөл нь урт, зун нь харьцангуй богино, хавар, намар нь тэнцүүхэн болдог эх газрын уур амьсгалтай бөгөөд энэ орчны нэг гол онцлог юм. /График 1/.

График 1

4 улирлын хугацаа



Орчны нэгэн адил эрт өвлийн шинж орж X сарын 26-аас дараа оны IV сарын 01 хүртэл 157 хоног үүргэлжилдэг нь манай орны хойд хэсгээс харьцангуй богино. Амандаа дуулавтар боловч уул хөндийн салхины жавартай жиндүү, өвөлдөө өглөө, оройн нар хүүшлэлт ихтэй байдаг. /Хүснэгт 1/.

Жилийн 4 улирлын хугацаа

Хугацаа	Өвөл	Хавар	Зун	Намар
Эхлэх	26.X	1.IY	30.Y	1.IX
дуусах	1.IY	30.Y	1.IX	26.X
хоног	157	59	94	55

Өвөл: Өвлийн улирал 10 дугаар сарын сүүлээс 4 дүгээр сарын эхэн хүртэл 157 хоног үргэжлэх бөгөөд манай орны дундаж улиралын хугацаанаас урт үргэжлэж өвлийн гол онцлог нь цаг агаар тогтуун, нарны өндөр хамгийн бага, цасан бүрхүүл тогтвортой тогтож, хүйтэн туйлдаа хүрч, өвлийн сүүлээр аажимдаа суларч хавар урь орно.

Хавар харьцангуй эрт урь унах үеэр 4 дүгээр сарын 01-ээс эхлэн алгуур дулаарч 5 дугаар сарын 30-нд дуусч 54 хоног үргэлжилдэг. Тэхдээ -5 хэмээс +10 хэмийн хооронд хэлбэлзэх боловч эхэн үедээ эрс хүйтэрч өвлийн шинжтэй, сүүл рүүгээ эрс дулаарч зуны шинжийг илтгэнэ.

Зун харьцангуй урт болж хаврын эцсээс намрын эх хүртэл 94 хоног үргэлжилдэг. Зуны улирал нь хамгийн тааламжтай цаг боловч хур борооны улирал учир 1-5 цаг үргэлжилсэн бороотой байх өдрүүд тохиолдоно. Зарим тохиолдолд зуны сүүлээр 1-3 хоног бороо үргэлжлэн орно.


Намар, зуны төгсгөл 9 дүгээр сарын 01-ээс 10 дүгээр сарын 26 хүртэл хавартай адил 55 хоног үргэлжилдэг. Хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц хэм тэнцүү болдог. Намар сэрүүн, заримдаа хүйтэвтэр нөлөө үйлчлэлтэй.

1.2.2 Нарны цацраг гийгүүлэл

Нарны гийгүүлэл жилдээ 2733 цаг үргэлжилдэг нь боломжит хугацааны 60% орчмыг эзэлдэг орчны уул зүй, өглөө, оройн нарны халхагдал болон хот орчмын үүлшил, агаарын булингаршил, хотын цаг агаартай холбоотой буурдаг.

Нарны гийгүүлэл хоног, сар, жилийн хугацаагаар цэлмэг үед нэн тодорхой явцтай байна. Нэг өдөрт дунджаар жилдээ 7-8 цаг нар гийгүүлэхдээ үүлшлээс хамаарч хэлбэлзэх боловч зуны саруудад 8.5-9.5, цаг өвлийн саруудад богиносч 5-6.5 цаг нартай байдаг. /График 2/.

График 2



Нарны цацраг, гийгүүлэл, үүлшил, нарны өндрөөс ихээхэн хамааран жилдээ нийлбэр цацраг 4390 мДж/м², шулуун цацраг 2676 мДж/м² тус тус ирдэг. Нарны цацраг нарны өндөр ихссэн, үүлшил бага байдаг 5,6 дугаар саруудад хамгийн их, нарны өндөр хамгийн бага 12 сар болон өвлийн саруудад бага байдаг.

2.2.3 Агаарын температур

Газрын гадаргад жилийн туршид ирэх нарны цацрагийн хэмжээ өөр өөр байх учраас температур өвөл бага, зун нь их байдаг. 1-р сард хамгийн бага хэмжээнд, 7-р сард дээд хэмжээндээ хүрч цаашид буурах хандлага илрэх бөгөөд жилийн турш ийм хэлбэлзлийг агаарын температурын жилийн явц гэнэ. Төсөл хэрэгжиж буй орчмын агаарын хэм хүйтэн нь I, XII сард дунджаар -19.1-ээс -9.8 хэм, голуудын хөндий савд -21-ээс -23 хэм, уул нуруундаа -20 – -21 хэм хүйтэн, VII сард хамгийн дулаан хэм уул нуруундаа +14 хэмээс сэрүүн, голын хөндий нутагт арай дулаан +14.9-+16.1 байна/Хүснэгт 2/.


Хүснэгт 2 Сар, жилийн дундаж агаарын температур (C)

Он	Сар												Жил
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
2013	-20.9	-16.5	-7.1	2.3	10.1	14.	16.3	14.2	10.3	0.2	-10.6	-21.1	-07
2014	-16.	-16.6	-6.2	0.8	9.5	13.5	15.8	14.3	7.7	1.	-6.	-13.	0.4
2015	-14.1	-16.1	-4.9	6.	8.3	13.9	16.9	15.	7.9	1.8	-7.	-14.6	1.2
2016	-12.5	-12.	-5.5	4.4	8.6	15.7	26.	17.6	8.6	3.4	-10.3	-11.4	2.2
2017	-19.2	-12.2	-3.3	3.	9.	14.4	18.8	15.5	10.2	-3.4	-11.4	-11.8	0.8
2018	-16.2	-11.3	-4.2	5.4	12.	17.7	19.5	15.3	9.4	0.9			

2.2.4 Хур тунадас, чийгшил

Төсөл хэрэгжих орчны жилийн дундаж харьцангуй чийгшил 66 хувь орчим, өвлийн саруудад 75-79 хувь, зуны саруудад 66-72 хувь, хаврын саруудад хамгийн хуурай 45-50 хувь, намар 55-60 хувь болно. Хоногийн аль нэг хугацаанд 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо хавар 20-30 орчим байдаг.

Хавар салхины хурд, нарны цацраг, агаар, хөрсний бохирдол, усны ууршилт ихэсдэг үе юм. Өдрийн 13 цагт 80 хувиас их чийгтэй өдрийн тоо 36 орчим болно.



Монгол орны хур тунадасны жилийн дундаж хэмжээ

2.2.5 Цасан бүрхүүл

Жил бүрийн 10-4 сард 150 гаруй хоног тогтвортой цасан бүрхүүл тогтож ихэвчлэн 7-10 см зузаантай, хамгийн зузаан үедээ 25-40 см хүрнэ. Хоногт 3-5 мм цас унадаг, дунджаар 0.13-0.30 г/см³ нягттай, 20-38 мм орчим нөөц услагтай байна.

Төсөл хэрэгжих нутагт анхныг цас 10 дугаар сарын дундуур, тогтвортой цасан хучаас 11-р сарын дундуур тогтож, 3-р сарын сүүлчээс цас ханзрах ба сүүлийн цас 4-р сарын дундуур хайлна. Ийнхүү 125 хоног цасан хучаастай байна. Гэхдээ мэдээж уул эрт зузаан цасаар хучигдана.

2.2.6 Агаарын даралт, салхины горим

Өвлийн улиралд их хүйтэн агаар хуримтлагдан удаан хугацаагаар тогтворжсоноос агаарын доод үеийг хөргөж даралтыг их болгодог.

Мөн хойд туйлын хүйтэн агаар дагнаж эсрэг циклоны нөлөөлөл хүчтэй болдгоос агаарын даралт жигд их болж 1 дүгээр сард агаарын дундаж даралт 1037.7-1041.8 мб-ын хооронд хэлбэлзэнэ. Агаарын жилийн дундаж даралт 846 гПа байна. Харин 8, 9, 11 дүгээр сард даралт температураасаа хамаарах гажна. Энэ нь Азийн эсрэг циклон эхэлж тогтоход дулааны хүчин зүйлээс хамаарал гадна динамик хүчин зүйлийн нөлөө нэмэгдэж байгааг илтгэнэ.

Хүснэгт 3 Агаарын даралт

Станцын нэр	Өндөр	Сарууд												
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Аргалант	1267 м	75.8	75.0	82.4	70.6	68.8	67.3	66.8	69.5	72.3	85.7	75.1	75.7	72.1

Салхины горим нь тухайн нутгийн уул зүйн онцлог, агаар мандлын ерөнхий орчин урсгалаас хамаарна. Дулаан, хүйтэн, чийг, хур тунадас зэрэг цаг уурын элементүүд нь салхиар зөөгдөн шилжих бөгөөд салхины хүч ихсэхтэй холбоотой цасан болон шороон шуурга, цаг агаарын аюултай үзэгдэл үүсэх тул салхи нь цаг уурын хамгийн чухал хэмжигдэхүүн юм.

Салхины зүг чигийг мэдэх нь тухайн орон нутгийн онцлогт тохируулж барилга байшин барих, тээвэр, холбоо, цахилгаан эрчим хүчний салбарт чухал ач холбогдолтой. /Хүснэгт 4, Зураг 6/.

Хүснэгт 4 Салхины зонхилох чиглэл

Станц	Х	ЗХ	Зу	З	у	Бу	Б	БХ	Салхигүй үе
Аргалант	36.3	9.4	17.2	3.8	0.1	0.9	14.3	41.1	52.6


Хүснэгтээс үзэхэд, баруун хойд зүгийн салхи давамгайлж байна.

Салхины хурд 0-1 м/сек байх давтагдал 46.0-50.9 хувь, 2-5 м/сек байх нь 26.6-35.0 хувь, 6-10 м/сек байх нь 0.2-1.4 хувь, 15 м/сек-ээс их байх нь 0.1-0.3 хувь байна. 15 м/сек-ээс их буюу хүчтэй салхитай өдрийн тоо жилд дунджаар 7-12 хоног байх боловч зарим жил 25-30 өдөр хүрдэг.

Жилд дунджаар 27-32 өдөр шороон шуурга, 7-18 өдөр цасан шуурга шуурдаг байна.

График 3

Салхины чиглэлийн давтагдал



2.3 Агаарын чанар

Хүрээлэн буй орчны бохирдолт их хэмжээгээр нэмэгдэж байгаа нь хот суурин газрын иргэдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж, улмаар ХХI зуунд дэлхий нийтийн айдас болсон экологийн хямралыг үүсгэж байгаа боловч манай орны хүн амь хэт төвлөрсөн гурван том хотын нэг болох Төв аймгийн агаарын чанарт хийсэн судалгаагаар бохирдлын зэргээрээ Улаанбаатар, Дархан Эрдэнэт хотуудын дараа ордог.

Төсөл хэрэгжиж буй газар нь Төв аймгийн суурьшлын бүсээс зайдуу байрладаг тул харьцангуй цэвэр тунгалаг агаартай бөгөөд өвлийн улиралд гэр хорооллын айл өрхүүдийн яндангаас гарах утаа сарнимал байдлаар үе үе тохиолдоно.

2.4 Геоморфологи

Судалгаа явуулсан газар нь баруун, зүүн талаараа хавтгай бөмбөгөр оройтой уулсаар хүрээлэгдсэн. Уулын бэл хэсэгт далайн түвшнээс дээш 1220 метр өндөрт, газрын гадаргын төрх байдал нь налуу тэгшивтэр гадаргуутай байна.

Хөрс: Тухайн газрын хөрс нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн уур амьсгалын их мужийн хагас чийглэг өндөршлийн бүсчлэл болох Хэнтийн өмнөд тойрогт багтана. Төсөл хэрэгжиж буй газрын хөрсний ерөнхий төлөв, шинж чанарыг төлөөлж чадхуйц газрыг сонгон өнгөн үе давхарга /0-15см/ -аас дээж аван ШУА-ийн Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Хөрсний лабораторид хөрсний химийн үндсэн шинж болон хөрсний механик бүрэлдхүүн зэрэг хөрсний задлан шинжилгээг хийлгэв.

Хүснэгт 1

Хөрсний химийн үндсэн шинж

Дээжний дугаар	Гүн, см	pH _{H2O} (1:2.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} Ds/m	Хөдөлгөөнт Мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Хөрс	0-20	7.61	0.0	11.71	0.036	1.5	3

Хүснэгт 2

Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, %(мм-ээр)		
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
Хөрс	0-20	42.8	31.3	24.9

Ургамал: Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Хэнтийн уулын тайгийн тойрогт багтана. Ургамлан нөмрөг нь экосистемийн гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энд амьдарч байгаа амьтдын тэжээлийн эх үүсвэр болдог. Иймээс экосистемийн тэнцвэрт байдлыг хэвээр хадгалах хамгаалахын тулд ургамлын бүгэмдлүүдийн өөрчлөгдөх сэргэх байдлыг танин мэдэх онол практикийн ихээхэн ач холбогдолтой.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлын судалгаагаар төсөл хэрэгжиж буй газрын ургамлан нөмрөг нь аж ахуйн бүлгээр нь тодорхойлоход алаг өвст-улалжит, алаг өвс-үетэн зонхилон ургадаг аж.

Геологийн тогтоц: Геологийн тогтоцын хувьд Хангайн геосинклиналь хотгорт харьялагдана. Районы геологийн тогтоцод Доод карбон,доод Цэрд, Неоген, Дөрөвдөгчийн хурдас чулуулаг, Мезозойн интрузив бүрдэл оролцоно.

3.1 Шууд нөлөөлөл

Төслийн нөлөөллийг тогтооход үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөллийн тоо 10 байна. Эдгээр нөлөөлөлд газрын доорх усны нөөц горимын өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, Тусгай хамгалалттай газар нутагт нөлөөлөх нөлөөлөл, тархалтын өөрчлөлт, ахуйн зориултаар ашиглах усны нөөц, агаарын бохирдол, зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, дуу шуугианы нөлөөллүүд сөрөг нөлөөлөлд хамаарч байна.

3.2 Шууд бус нөлөөлөл

Энд 17 төрлийн нөлөөлөл багтаж байна. Гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний үржил шим, газрын доорх усны чанарын

өөрчлөлт, гадаргын усны чанарын өөрчлөлт, хөрсний бохирдол, ургамлан нөмрөгийн бохирдол, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр, дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, хөрсний усыг бохирдуулах, ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гаргах, ялаа батгана үржих, хүчтэй салхи, шуурга, үер, гал түймэр, газар хөдлөл, аянга зэргээс үүдэн гарах аюул осол.

3.3 Болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төслийн нөлөөллийг үргэлжлэх хугацааных нь хувьд богино хугацааны нөлөөлөл 1, дунд хугацааны нөлөөлөл 21, урт хугацааны нөлөөлөл 4 байна.

Богино хугацааны нөлөөлөлд: Хүчтэй салхи шуурга, үер, гал түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн гарах аюул осол нь богино хугацааны нөлөөлөлд хамаарна.

Дунд хугацааны нөлөөлөлд: Газрын доорх усны нөөц, горимын өөрчлөлт, Гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний үржил шим, ахуйн зориулалтаар ашиглах усны нөөц, газрын доорх усны чанарын өөрчлөлт, гадаргын усны чанарын өөрчлөлт, агаарын бохирдол, хөрсний бохирдол, ургамлан нөмрөгийн бохирдол, ахуйн бохир ус нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, хөрсний усыг бохирдуулах, ахуйн бохир усны цооног, бие засах, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гаргах, ялаа батгана үржих;

Урт хугацааны нөлөөлөлд: Байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх нөлөөлөл, зам харилцаа машин механизмаас хөдөлгөөнөөс хөрс эвдрэх зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Харин улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, орон нутагт ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, шинээр ажлын байр нэмэгдэх зэрэг нь дунд хугацааны эерэг үр дагавартай байна.

3.4 Нөлөөллийн буцах болон эргэлт буцалтгүй байдал

Газрын доорх усны нөөц, горимын өөрчлөлт, гадаргын усны нөөц горимын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт тархалтын өөрчлөлт, хөрсний үржил шим, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр дүрс, өнгө төрх өөрчлөгдөх, зам харилцаа, машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, хөрсний усыг бохирдуулах гэх мэт нөлөөллүүд хамаарна.

Харин хүчтэй салхи шуурга, үер, гал түймэр, газар хөдлөл, аянга зэргээс үүдэн гарах аюул осол, дуу шуугианы нөлөөлөл зэрэг 2 нөлөөлөл нь эргэж нөлөөлж болзошгүй тул тэдгээр нь буцах нөлөөлөлд хамаарна.

3.5 Нөлөөллийн эрчимшил

Төслийн нөлөөллийг эрчимшлийн хувьд авч үзвэл нийт нөлөөлөлд хүчтэй нөлөөлөл байхгүй, сулавтар эрчмийн нөлөөлөл 8, бага эрчмийн нөлөөлөл 12, дунд, 6 эрчимшилтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, шинээр ажлын байр бий болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг тухайн нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллүүд нь дунд зэрэг эрчимшилтэй байна.

3.6 Төслийн байршил, шийдэл, төлөвлөлтөөс үүсэх нөлөөлөл

Төслийн эргэн тойрны өвөлжөө, хаваржаа, айл өрх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх асуудал гарахгүй. Иймд төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудлын хувьд харьцангуй тааламжтай нутаг дэвсгэр юм.

Төслийн үйл ажиллагааны хувьд авч үзвэл, голын голдрилыг өөрчлөх, ухаж эвдэх, ой модыг огтолж гэмтээх, түүх соёлын дурсгалт газар болон археологи, палеонтологийн олдворт газрыг ухаж эвдэх зэрэг сөрөг нөлөөлөл огт үүсэхгүй.

Мөн гэнэтийн болзошгүй ослын үед хэрэгжүүлэх ажлын удирдамж төлөвлөгөөтэй байх нь зүйтэй. Ажиллагсадын ахуйн хог хаягдлыг зориулалтын тагтай саванд хадгалан Засаг даргын шийдвэрээр тогтоосон төв суурин газрын хог хаягдлын нэгдсэн цэг зайлуулах шаардлагатай.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянаж байх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, мөн уг аргачлалын 4 дэх хэсэгт заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, зураг төсөл зэрэгт тулгуурласан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-нд тухайн баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, хэрэгжүүлэх цаг хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлээ. “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-гөө боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан ажиллана.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, хяналт-шинжилгээ хийх хуваарь, давтамж, сорьц дээж авах цэгийн байршил, баримтлах стандарт, түүнийг тодорхойлох арга аргачлал, шаардагдах зардлыг тооцож, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, мод, сөөг тарьж цэцэрлэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийж гүйцэтгэх ажил, шаардагдах зардлыг тооцож тусгасан. Энэхүү төлөвлөгөө нь Байгаль орчны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийгдсэн болно.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичгүүд
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаар									
1.	Тоосжилт, утаа, зохисгүй үнэр үүсэж тархан орчны агаарын чанарт нөлөөлөх.	- Тоосжилт үүсэх ямар нэг эх үүсвэр гаргахгүй байх, Тухайлбал, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, төлөвлөгдөөгүй газарт нүх ухах зэргээр хөрсийг гэмтээх гм	Төсөл хэрэгжиж буй орны агаар	Төг	50.0	1	50.0	2024	- “Агаарын тухай” хууль, 2012 он - “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль, 2010 он; - MNS 4585:2007 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”; - MNS (ISO) 4226:2000 “Агаарын чанар”; - MNS 4585:2008
2.	Хавар, намрын хуурайшилттай улиралд ил гал гаргах, татсан тамхиа ил хаях зэргээс үүдэн гал алдах нөхцөл үүсэн	Татсан тамхи, ил асаасан галыг заавал унтрааж байх, зортулалтын газар, зориулалтын битүү саванд хаяж байх талаар санамж, анхааруулгыг ил байршуулах	Орчны агаар агаар бохирдох	Галд тэсвэртэй хог хаягдлын сав байршуулах	50.0	1	100.0	2024	
Гадаргын болон газрын доорхи ус									

“Об Ойл Индастриал” ХХК-ний хэрэгжүүлж буй “Хаягдал түүхий эд боловсруулан шаатахуун үйлдвэрлэх” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.	Ахуйн хог хаягдлыг ил задгай хаях зориулалтын бус саванд хадгалах, ил задгай хаях зэргээс үер ус болон салхиар зөөгдөн гадаргын усыг бохирдуулах	- Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах - Тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Орчны хөрс, гадаргын ус	ш	50.0	2	100.0	2024 он	- “Усны тухай” хууль, 2012 он; - “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль, 2012 он; - MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”;
2.	Унд ахуйн болон бусад хэрэгцээний усыг их хэмжээгээр замбараагүй хэрэглээ	- Усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах - Анхааруулга, санамж байршуулах - Тоолууржуулах	Газрын доорхи ус	ш	20.0	10	200.0	2024 он	
Хөрсөн бүрхэвч									
1.	Олон салаа зам гаргаснаас хөрс элэгдэж эвдрэх	- Олон салаа зам гаргахыг хориглосон тэмдэг тавих, - Зураг төсөлд тусгаагүй газарт нүх ухах, барилга байгууламж барихыг хортглох	Орчны хөрс	ш	100.0	2	200.0	2024 он	
2.	Ногоон байгууламжийн арчилгаа, Мод сөөг тарьж ургуулах үедээ химийн бодис бордоог зөвшөөрөлгүй, хэрэглэснээр хөрс үржил шим алдах бохирдох.	- Ногоон байгууламж, мод сөөг тарих, арчлах үед хор бордоо хэрэглэхдээ мэргэжлийн зөвөлгөө авч, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Хөрс доройтох	Хяналт тавих ажилтны урамшуулал	100.0	2	200.0	2024 он	- Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012.05.17 - Хог хаягдлын тухай хууль, 2017.05.12
3.		-							
Газрын хэвлий									
1.	Барилга байгууламж барих үед газрын	Санамж анхааруулга байнга өгч байх Зураг төсөлд заагаагүй газарт нүх ухах .	Газрын хэвлий гэмтэж гуу	ш	100.0	1	100.0	2024 он	- Газрын тухай хууль 2002.06.07

“Об Ойл Индастриал” ХХК-ний хэрэгжүүлж буй “Хаягдал түүхий эд боловсруулан шатахуун үйлдвэрлэх” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	хэвлийд эвдрэлд үүснэ.		жалга үүсэх							- Газрын хэвлийн тухай хууль, 1988.11.29
Ургамлан нөмрөг										
1.	Хашааны дотор болон гадна талбайд зориулалтын замгүйгээс ургамлан нөмрөг устах, гэмтэх	Зориулалтын хайрган, чулуун болон хатуу хучилттай зам барих, элэгдэлд орсон, доройтсон газрыг байнга тордох, сэргээх, мод бут тарих, ургамалжуулах	Эзэмшил газрын хүрээнд	м ²	20.0	10.0	200.0	2024 он		- Ургамал хамгааллын тухай хууль, 2007.11.15 - Хог хаягдлын тухай хууль 2017.05.12
Амьтны аймаг										
1.	Ил задгай хаясан хог хаягдал болон бохирдсон өвс, ургамалыг мал амьтан идэж хордох	- Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах, - Ялзарч муудаж болзошгүй эд зүйл, хоол хүнсий үлдэгдлийг ил задгай хаяхгүй байх, анхааруулга, санамж байршуулах:	Төсөл хэрэгжиж буй орчинд байрлаж буй, байрлаж болох мал амьтан	ш	20.0	1	20.0	2024-2027 он		- Амьтны тухай хууль, 2012.05.1 - Хог хаягдлын тухай хууль 2017.05.12
АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ ЗАРДАЛ:			1070.0 МЯН.ТӨГ							

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Төслийн объектийн орчныг тохижуулах.	Үржил шимт хөрсөөр хучилт хийх Олон наст ургамал тарих, зүлэгжүүлэх	0.6 га талбайн 10-аас доошгүй хувьд	М ²	600	2.0	1200.0	2024 он	MNS5918:2008 эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
2.	Орчны ая тухтай нөхцөлийг бүрдүүлж, хүлэмжийн хийн/CO2/ ялгаралыг бууруулах	Цэцэрлэгжүүлэх Цэцгийн мандал ургуулах	200 м ² талбайг зүлэгжүүлэх	М ²	200	3.0	600.0	2024 он	
				ш	2	50.0	100.0	2024 он	
Нийт							1900.0		

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн газрын судалгааны явцад түүх соёлын өв, дурсгалт зүйлс бүртгэгдээгүй. Болзошгүй тохиолдолд дараах араг хэмжээг авна.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Төслийн үйл ажиллагаа эхлэн газар шорооны ажил хийгдэх үед түүх, соёлын өв, эд зүйлс өртөж хөндөгдөж болзошгүй.	Түүх соёлын эд зүйлс илэрсэн тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, хамгаалалт хийж, харьяа дээд шатны Засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэнэ.	-	-	-	Болзошгүй зардлаас	-	-Соёлын тухай хууль

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	-Ахуйн хатуу хог хаягдал, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс агаар, хөрс, усыг бохирдуулах, сөрөг нөлөөлөл учруулах.	Тайлангийн 5.1-д тооцсоны дагуу жилд 1.0 тн хог хаягдал гарна. -Хатуу хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг байршуулах, -Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эрх бүхий байгууллагад хүргэж өгөх; Ахуйн шингэн бохирыг төвийн нэгдсэн шугаманд нийлүүлж төлбөр төлөх гэрээтэй байх	Ашиглаж буй талбайн орчин	тн	240.0	1.0	240.0	2024	-“Хог хаягдлын тухай” хууль, 2017 он; шинэчилсэн найруулга -MNS 5924:2008 . Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага
2				тн	300.0	2	600.0		
	Нийт						840.0		

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгж йн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Бохир шингэн дамжуулах шугам орчимд	Хагас жилд	3	80 000	480.0	2024 онд	“Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах”; - MNS 5850:2008 “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”; -ISO15799:2003 MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS4943:2011“Ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт усны химийн шинжилгээ болон дээж авах, хадгалах”; MNS(ISO)5667-5:2001 “Усны чанар- дээжлэлт”
2.	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо - Усны чанар: рН, ууссан нийт давс	Цэвэр усны нэгдсэн системийн эх үүсвэр болон	Хагас жилд	3	30 000	180.0	2024 онд	
3.	Ундны усны бүрэн шинжилгээ. Нийт хатуулаг: (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид	Үндсэн шугамаас	Хагас жилд	2	40 000	160.0		
Нийт						820 000		

10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			4-р сар	-	11-р сар		
1	2	3	4	5	6	7	
1.	Байгаль орчныг хамгаалах асуудлаар жилийн ажлын тайлангаа тогтоосон хугацаанд нь гаргаж өгч, холбогдох дээд шатны байгууллагуудтай хамтарч ажиллах.	600000	300 000	-	300 000	“Об Ойл Индастриал” ХХК	2024 он
2.	Байгаль орчны аудитыг 2 жил тутам хийлгэх	2 000 000	-	-	-		2024 он
Нийт		2 600 000					

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	БОАЖЯ	Хяналт шалгалтын байгууллагын хяналтын хуудсаар	Төслийн бүхий л шатны үйл ажиллагааг	2024 он	500000	“Об Ойл Индастриал” ХХК-ний Захирал	БОАЖЯ
2	Иргэн, аж ахуйн нэгж албан байгууллагад	Төслийн танилцуулга, ерөнхий үйл ажиллагаа	Уулзалт, танилцуулга зохион байгуулах	2024 он			
Нийт					500 000		

Байгаль орчны менежментийн нийт зардал нь **7 сая 730** мянган төгрөг үүнээс Хяналт шинжилгээний хөтөлбөрт **820** мянган төгрөг байна.

“Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөө”-ний нэгдсэн дүн

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, мян.төг	Хариуцах эзэн
1.	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	1070.0	Об Ойл Индастриал
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлт	1900.0	Об Ойл Индастриал
3.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	Об Ойл Индастриал
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	840.0	Об Ойл Индастриал
5.	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	820.0	Об Ойл Индастриал
6.	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	2600.0	Об Ойл Индастриал
7.	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	500.0	Об Ойл Индастриал
НИЙТ ЗАРДАЛ/мян.төгрөг/		7730.0	

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ, НОМЗҮЙН ЖАГСААЛТ:

1. Байгаль орчны хуулийн эмхтгэл 2012
2. Газар зүйн атлас 2003
3. Монгол орны байгаль орчин Улаанбаатар 1996.
4. Г.Намхайжанцан. Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД-01.01-93. УБ,1994.146х
5. Г.Намхайжанцан. Амьд биед цаг уур нөлөөлөх нь зурхай. УБ,1991 11(12).
6. Г.Намхайжанцан. Монгол орны амралт, рашаан сувилал, аялал жуулчлалд зориулсан био уур амьсгалын мужлал. УБ,1992.
7. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Д.Мягмарсүрэн, А.Намхай, УБ, 2012
8. Монгол улсын үндэсний атлас, Газарзүйн хүрээлэн 2009 он
9. Монгол орны гадаргын ус Г.Даваа, УБ, 1999 он
10. Танд ямар рашаан хэрэгтэй вэ? О.Намнандорж УБ, 2007
11. Flowers of Hustai National Park. Ulaanbaatar 2008
12. Монгол орны байгаль орчин Улаанбаатар 2007-2009
14. УЦУ Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл 16.х.63-66.
15. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Д.Мягмарсүрэн, А.Намхай, УБ, 2012
13. Монгол орны гадаргын ус Г.Даваа, УБ, 1999 он
14. “Эко Натур” ХХК-ийн хээрийн судалгааны материал
15. Байгаль орчны менежментийг боловсронгуй болгох аргачилсан зөвлөмж УБ 2006 он
Байгаль орчны яам
16. Байгаль орчин эрх зүйн баримт бичгийн эмхтгэл УБ 2005 он
17. Ногоон хөгжлийн бодлого УБ 2015 он Байгаль орчин, аялал жуулчлалын яам